

УУЛ УУРХАЙН КОМПАНИУДЫН САНХҮҮГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Л.Наранчимэг*, Ө.Ариунболд**

Хураангуй: Монголын уул уурхайн салбарын компаниудын санхүүгийн өнөөгийн төлөв байдлыг 2015-2017 оны санхүүгийн тайлангийн болон статистикийн мэдээлэлд тулгуурлан тус салбарыг төлөөлөхүйц 19 компани тоо мэдээлэлд тулгуурлан судалгааг хийлээ.

Судалгаанаас үзэхэд Монголын эдийн засагт уул уурхайн салбарын хувийн жин өсөж, эдийн засгийн өсөлтөнд эерэг нөлөөллийг үзүүлж байгаа хэдий ч уул уурхайн салбарын компаниудын санхүүгийн төлөв байдал нь тогтворгүй, нийт өрийн харьцаа өндөр, хөрөнгийн ашиглалт, өгөөж сайнгүй байна.

Санхүүгийн үзүүлэлтүүдийн хамгийн бага утгыг хангах үеийн хөрөнгө, эх үүсвэрийн бүтцийн оновчтой байдлыг тодорхойлж дүгнэлт гаргасан болно.

Түлхүүр үгс: Компанийн хөрөнгө, санхүүжилтын бүтэц, эдийн засгийн өсөлт, санхүүгийн үзүүлэлтүүд,

Abstract: This research aims to define the financial performance of the Mongolian mining industry based on financial statements and statistical data from 2015 to 2017 of 19 companies which are capable of representing the industry.

As a result, the proportion of the mining industry on the economy increased and it has a positive effect on the economy. However, companies of mining sector show inconsistent financial position such as high total liability ratio, poor utilization, and profitability.

The result of this research identifies optimal capital structure when financial performance reaches the lowest point.

Keywords: Company assets, structure of funding, economic growth, financial indicators

* МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) naranchimeg_L@num.edu.mn, naraalombodorj@gmail.com

** МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) ariunbold.ulziibat@yahoo.com


Нэг. Уул уурхайн салбарын өнөөгийн байдал

Эрдэс баялгийн салбарын талаар төрөөс баримтлах бодлого нь дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн түгээмэл үзэл, хандлагын хүрээнд газрын хэвлийн баялгийнхаа давуу байдалд тулгуурлан байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэнцлийг хангасан харилцан ашигтай, ил тод, хариуцлагатай, хүний эрүүл мэндэд халгүй, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник, технологи, менежмент нэвтэрсэн олборлох болон нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, иргэдийн амьжиргааны түвшин, чанарыг тасралтгүй дээшлүүлэхэд чиглэгдэнэ³.

Монгол Улсын Засгийн газар экспортын чиг хандлагатай үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд уул уурхайн салбарыг тус орны эдийн засгийн тэргүүлэх салбарын хэмжээнд авч үзэн хөрөнгө оруулагчдад байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, тэргүүний техник, технологийг нэвтрүүлэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг чухалчилж байна.

Эрдэс баялгийн салбарын удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн хүрээнд компанийн удирдлагын чадвар, хариуцлагыг эдийн засаг болон санхүү, тухайлбал ашигт ажиллагааны түвшин, бүтээмж, найдвартай байдлын голлох үзүүлэлтээр тогтмол хугацаанд дүгнэж олон нийгэд мэдээлэх байдлаар хариуцлага, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, улмаар корпорацийн хэлбэрт шилжүүлэх, нээлттэй хувьцаат компани болгох үйл ажиллагааг судалгаанд үндэслэн хийнэ гэж төрөөс тодорхойлсон. 2017 оны байдлаар уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт 753 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж, нэг ажилчны сарын дундаж цалин 2,3 сая төгрөг байна. Аж үйлдвэрийн салбарын ажиллагчдын 52.0 мянга буюу 31.1 хувь нь уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт, 93.1 мянга буюу 55.6 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 22.3 мянга буюу 13.3 хувь нь цахилгаан хий үйлдвэрлэл, ус хангамжийн салбарт ажиллаж байна.

Аж үйлдвэрийн салбар нь манай улсын эдийн засгийн хөгжилд голлох байр суурь эзэлдэг билээ. Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн 2017 оны байдлаар (оны үнээр) 27.2 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд 8.9 их наяд буюу 32.7 хувийг аж үйлдвэрийн салбар бүрдүүлж байна.



³ Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, 2013-2024 он


2017 оны байдлаар аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөгт уул уурхай, олборлох үйлдвэрийн салбар 66.9 хувь, боловсруулах салбар 26.3 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалтынх 5.5 хувь, усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежментийнх 1.3 хувийг тус тус эзэлж байна. Аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөгт уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын эзлэх хувийг 1990 оноос 2017 оны хооронд авч үзвэл 1990 онд хамгийн бага буюу 35.2 хувь байсан бол 2006 онд хамгийн их буюу 77.9 хувь байжээ.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо, нэр төрөл

2018 оны 12-р сарын 31-ээрх байдлаар 3078 тусгай зөвшөөрөл						
Ашиглалтын 1673			Хайгуулын 1405			
78,7% дотоодын ХО-тай		6,6% хамтарсан ХО-тай		14,7% гадаадын 100% - ийн ХО-тай		
Гадаадын 100% хувийн хөрөнгө оруулалттай тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн бүтцийг улсаар нь авч үзвэл: 37%-Хятад, 18,2%-Виржиний Арлууд, 14,2%-Сингапур, 3,7%-Өмнөд солонгос, 5,8%-Канад, 5,8%-Хонг-Конг, 4,2%-Голланд						
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, нэр төрлөөр нь						
Алт 32,9%	Барилгын материал 18,8%	Жонш 10,8%	Гянтболд 1,7%	Нүүрс 18,8%	Төмөр 4,1%	Бусад 12,9%

2018 оны 12-р сарын 31-ны байдлаар улсын хэмжээнд нийт 3078 тусгай зөвшөөрөл байгаагаас ашиглалтын 1673, хайгуулын 1405 байна⁴. Энэ нь Монгол улсын нутаг дэвсгэрийн 9-10 хувийг эзэлж байна.

Зураг 3.



Уул уурхай, олборлох үйлдвэрийн дэд салбар нь аж үйлдвэрийн салбарт томоохон хувийн жин эзэлдэг чухал салбар юм. Уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэр төрлөөр нь дараах 5 дэд салбарт ангилна. 1. Нүүрс олборлолт 2. Газрын тос олборлолт 3. Металлын хүдэр олборлолт 4. Бусад ашигт малтмал олборлолт 5. Уул уурхай, олборлолтын туслах бусад үйл ажиллагаа Сүүлийн жилүүдэд уул уурхай, эрдэс баялгийн салбар хурдацтайгаар хөгжиж, Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болж байна. Стратегийн ач холбогдол бүхий томоохон ашигт малтмалын орд, газрууд

⁴ Эх сурвалж: Кадастрын хэлтэс, АМГТГ (<https://www.mrpm.gov.mn/public/pages/131/monthly-report.2018.12.mon.pdf>)

эдийн засгийн эргэлтэд орсон нь уул уурхайн салбарын үйлдвэрлэл цаашид өсөх нөхцөлийг бүрдүүлж байна. http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Industry_2017.pdf&ln=Mn

Хоёр. Уул уурхайн компаниудын санхүүгийн төлөв байдлын судалгаа

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д 2017 оны 12 сарын 31-ний байдлаар 218 ХК бүртгэлтэй байгаагаас 8.7 % буюу 19 ХК нь 100 хувь төрийн өмчит, 5.5% буюу 12 ХК нь төрийн өмчийн оролцоотой, 85.7% буюу 187 ХК нь бүрэн хувьчлагдсан компани байна. Харин бүртгэлтэй үнэт цаасны хувьд нийт 11.2 тэрбум ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаагаас 35.3 % буюу 3.97 тэрбум ширхэг нь төрийн мэдлийн, 64.7 % буюу 7.25 тэрбум ширхэг нь хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувьцаа байна⁵.

Бид судалгаандаа уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 19 компани сүүлийн 3 жилийн тоо мэдээг ашиглан тооцоо судалгаа хийхийг зорьлоо.

Сүүлийн 3 жилийн татварын мэдээллээс Монгол улсын хэмжэээнд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн салбарын компаниудын улсын төсөвт төвлөрүүлсэн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 92-96%, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 87-95% ийг бидний судалгаанд хамрагдсан 19 компани төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Уул уурхайн компаниудын хөрөнгө, эх үүсвэрийн бүтэц бүрэлдэхүүн

Үзүүлэлтүүд	Хувиар				Тэрбум төгрөг			2015-2017оны	
	2017	2016	2015	Дундаж	2017	2016	2015	Дундаж	Өсөлт %-нар
1. Хөрөнгийн бүрэлдэхүүн									
Эргэлтийн хөрөнгө	11.8	11.7	12.5	12	3,8	3,4	3,1	3,5	110,7
Эргэлтийн бус хөрөнгө	88.2	88.3	87.5	88	28,9	26,3	22	25,7	114,6
Дүн	100	100	100	100.0	32,7	29,7	25,1	29,2	114,1
2. Санхүүжилтийн бүрэлдэхүүн									
Өр төлбөр	88.2	90.9	87.4	89	28,9	27,1	22	26	114,6
Эзэмшигчдийн өмч	11.8	9.1	12.6	11	3,8	2,6	3,1	3,2	110,7
Дүн	100	100	100	100.0	32,7	29,7	25,1	29,2	114,1

Уул уурхай, эрдэс баялгын салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын сүүлийн 3 жилийн дунджаар тооцоход нийт хөрөнгийн 12 хувийг эргэлтийн хөрөнгө, 88 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байгаа боловч, сүүлийн жилүүдэд эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувийн жин 87,5-88,2 хувь болж

⁵ МХБ, 2017 оны жилийн тайлан, 13-р хуудас


нэмэгдэх хандлагатай байгаа нь хөрөнгийн хөрвөх чадвар суларч, эргэц удааширч байгааг илтгэж байна. Хөрөнгийн санхүүжилтын бүтцийн хувьд өр төлбөр 89 хувийг, өөрийн хөрөнгө 11 хувийг эзэлж өөрийн хөрөнгийн хувийн жин 12,6-11,8 болж буурчээ.

Сүүлийн 3 жилийн дундажаар тооцоход тус салбарын эргэлтийн хөрөнгийг бараг бүхэлд нь өр төлбөрөөр санхүүжүүлжээ. Аливаа бизнесийн байгууллагын далайц, өсөлтийн чиглэлийг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний тоо хэмжээ, нэр төрөл, борлуулалтын орлогод тэдгээрийн эзлэх хувийн жингээр тодорхойлохоос гадна эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн өсөлтийн динамик шинжилгээг тодорхой эрэмбэ дарааллаар хийх нь арга зүйн хувьд зохимжтой байдаг.⁶ Хөрөнгө эх үүсвэрийн бүтэц бүрэлдэхүүн тэдгээрийн өсөлтийн хурдыг Оросын эрдэмтэд дараах байдлаар тодорхойлжээ⁷

Хүснэгт 3. Хөрөнгө, эх үүсвэрийн өсөлт

	Өөрийн хөрөнгө	Эргэлтийн бус хөрөнгө	Нийт хөрөнгө	Эргэлтийн хөрөнгө	Гадны капитал
Нормативд зэрэглэл (R)	1	2	3	4	5
Гүйцэтгэлийн өсөлт бууралт (%-иар)	10,7	14,6	14,1	10,7	14,6
Гүйцэтгэлийн зэрэглэл (F)	4	1	3	5	2

График 1.



⁶ Б.Сайнжаргал “Санхүүгийн тайлангийн шинжилгээ” УБ хот 1999 он

⁷ Факторный анализ финансовой устойчивости КонСи

Дүрслэлээс харахад үзүүлэлт бүрийн нормативт болон гүйцэтгэлийн өсөлтийн утгуудын хооронд хамгийн их зөрүүтэй байгаа үзүүлэлт нь өөрийн хөрөнгийн өсөлт байна. (R1=F4) Энэ нь манай уул уурхайн компаниудын нийт хөрөнгийн зонхилох хэсэг нь уулын ажлын зориулалттай машин, механизмууд байдаг, тэдгээрийн дийлэнхийг гадны зээл (УХӨ) санхүүжилтаар бэлтгэдэг, гүйцэтгэсэн уул уурхайн ажил болон нийт хөрөнгө нэмэгдэхийн хэрээр өөрийн хөрөнгө нь тэр хэмжээгээр өсөж чаддаггүй (ашиглалт болон үр өгөөж нь муу)-г илтгэж байна⁸.

Хүснэгт 4. Уул уурхайн компаниудын санхүүгийн үзүүлэлтүүдийн судалгаа

Үзүүлэлтүүд	2015		2016		2017	
	1	2	1	2	1	2
1. Бие даалтын коэф	0.39	0.13	0.4	0.09	0.41	0.12
2. Зохицуулалтын коэф	1.28	-4.9	0.1	-0.8	0.14	-0.7
3. Өр төлбөрийн хэмжээ	0.61	0.9	0.6	0.9	0.58	0.9
4. Өрийн харьцаа эх үүсвэрийн кват	2.56	7.96	2.4	11.05	2.4	8.49
5. Эргэлтийн харьцаа	7.04	0.17	4.9	0.61	4.4	0.59
6. Нийт хөрөнгийн ашигт ажиллагаа	0.003	(0.03)	0.01	(0.03)	0.03	0.03
7. Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа	0.007	(0.26)	0.03	(0.38)	0.07	0.27

Эх сурвалж: МХБ-д бүртгэлтэй ХК-удын санхүүгийн тайлангийн хураангуй (2015-2017 он)

1 – МХБ-д бүртгэлтэй компаниудын дундаж

2- Уул уурхайн сонгон авсан (19) компаниудын дундаж

МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниуд болон сонгон авсан компаниудын дундажаар тооцоход санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд ерөнхийд С түвшинд байна. Өр төлбөрийн хувийн жин нэмэгдэхийн хэрээр өөрийн хөрөнгийн оролцоо буурч байгаа нь санхүүгийн тогтворжилт “хэвийн бус” буюу эрсдэлтэй түвшинд байгааг харуулж байна. Сонгон авсан уул уурхайн компаниудын хувьд өөрийн хэмжээ 12 орчим хувь байгаа нь өр төлбөр их байгааг, зохицуулалтын коэффициент сөрөг утгатай (-4,9) байгаа нь өөрийн хөрөнгөөрөө эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлж чадахгүй байгааг тус тус илтгэж байна.

⁸ Б.Сайнжаргал, Л.Наранчимэг “Уул уурхайн компаниудын санхүүгийн төлөв байдлын шинжилгээ, дүгнэлт” сэдэвт ОУЭШХ-ын илтгэл УБ хот 2014

**Гурав. Уул уурхайн компаниудын хөрөнгө,
эх үүсвэрийн зохистой бүтэц**

Хүснэгт 5. Балансын зорилтот бүтэц

ЭБХ= 28,903,990,010.5	ӨК= 3,862,573,239.8+ X ₁
ЭХ= 3,876,359,137.3+ (X ₁ -X ₂)	БХӨ= 6,616,277,676.2- X ₂
	УХӨ= 22,301,498,231.8
НХ=32,780,349,147.8+ (X ₁ -X ₂)	НХ= 32,780,349,147.8+ (X ₁ -X ₂)

Эх сурвалж: Судлаачийн тооцсоноор

X_1, X_2 – Зорилтот бүтцийг хангахын тулд балансын зарим зүйл ангийг өөрчлөх утга.

Энэ нь компани өөрийн хөрөнгөө X_1 – ээс багагүй хэмжээгээр нэмэгдүүлэх, харин богино хугацаат өр төлбөрөө X_2 – оос багагүй хэмжээгээр бууруулахыг зорих бөгөөд энэ нь эргэлтийн хөрөнгийг $X_1 - X_2$ – оос багагүй хэмжээгээр нэмэгдүүлэх чиг бодлогыг барих ёстойг илтгэх болно. Балансын бүтцийн зорилтот өөрчлөлт нь зөвхөн хөрөнгө, эх үүсвэрийн дүнгийн өөрчлөлт төдийгүй дараах хязгаарлалтууд болон тэнцвэрт харьцаануудыг хангасан байвал зохино. Хязгаарлалтуудыг Уул уурхайн салбарын дундаж үзүүлэлтүүдээс гадна сангийн сайдын 2015 оны 343-р тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал”-ийг баримтлан тогтоолоо.

Үүнд: Хязгаарлалт ба тэнцвэрүүд:

1. $\min(\delta_1 x_1 + \delta_2 x_2)$
2. $x_1 + x_2 \geq 2БХӨ - ЭХ$
3. $x_1 + x_2 \leq НХ - 2ЭӨ$
4. $x_2 \leq НХ - ЭӨ$
5. $0,1x_1 \leq ЦА - 0,1ЭӨ$
6. $x_1 - x_2 \leq 10ЦА - НХ$
7. $x_1 + x_2 \geq 2НӨ - НХ$

1-р нөхцөл буюу зорилгын функц нь: Балансын оновчтой бүтцийн тооцоог уул уурхайн салбарын сонгосон 19 компанийн дундажаар авч $\delta_1 x_1 + \delta_2 x_2$ – ийн дүнг хамгийн минимум түвшинд байлгах;

2-р нөхцөл нь: Уул уурхайн салбарын эргэлтийн харьцаа дундажаар 1:1, судалгаанд сонгон авсан 19 компанийн дундаж 0.5 байгааг нормативт түвшин буюу 2:1 гэсэн хэмжээнд хүргэх; 3 ба 4-р нөхцөл нь: Уул уурхайн салбарын

хувьд бие даалтын коэффициент 0.12, судалгаанд хамрагдсан 19 компанийн дундаж 0.1, байгааг 0,5-аас багагүй 1-ээс ихгүй болгох;

5-р нөхцөл нь: Өөрийн хөрөнгийн өгөөж нь салбарын болон 19 компанийн хувьд дундажаар (0.1) байгааг 0,1-ээс багагүй байлгах.

6-р нөхцөл нь: Нийт хөрөнгийн өгөөж нь салбарын дундажаар (0.01) хувь, байгааг нэмэгдүүлж 5 хувьд хүргэх.

7-р нөхцөл нь: Гадны капиталын хувийн жин 88,0 хувь байгааг бууруулж 50,0 хувиас ихгүй байлгах.

Дээрх нөхцөл тус бүрийг харгалзан үзэж solver программаар тооцоолоход сонгосон 19 компанийн зорилтот утгын дундаж дараах байдлаар тооцоологдлоо.

Хүснэгт 6. Хөрөнгө эх үүсвэрийн зорилтот утгын харьцуулсан тооцооны дүн (сая.төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	19 компанийн дундаж		+,- /%/
	2017 он	Зорилтот утга	
1. Эргэлтийн хөрөнгө	3876,3	6995	80,5
2. Эргэлтийн бус хөрөнгө	28904	28904	-
Нийт хөрөнгө	32780,3	35899	9.5
3. Богино хугацаатай өр төлбөр	6616,2	3497,4	-47.1
4. Урт хугацаатай өр төлбөр	22301,6	22301,6	-
5. Эзэмшигчийн өмч	3862,5	10100	161.5
Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн	32780,3	35899	9.5

Тооцооноос үзвэл уул уурхайн салбарын болоод төлөөлөх компаниуд бидний санал болгож буй балансын зорилтот хэмжээ(бүтэц)-г хангахын тулд:

1. Эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг одоо байгаа хэмжээнээс 80 хувиас доошгүй нэмэгдүүлэх.
2. Богино хугацаат санхүүжилтийн дүнг тус бүр 47 хувиар бууруулах
3. Хуримтлагдсан ашгийн өсөлт, хувьцаа нэмж гаргах болон бусад арга замаар эзэмшигчийн өмчийн дүнг 1.6 дахин нэмэгдүүлэх шаардлага тавигдаж байна.

Хөрөнгө эх үүсвэрийн бүтцийг хангах энэхүү бодлогын шийдийг ашиглан үйл ажиллагаандаа хэрэгжүүлснээр уул уурхайн компаниуд бие даан ажиллах боломж бүрдэх төдийгүй санхүүгийн тогтвортой байдал, хөрөнгийн ашиглалт, нийт болон өөрийн хөрөнгийн өгөөжийн хамгийн бага түвшинг хангахуйц балансын шинэ бүтэц бүрэлдэн тогтох юм.

Хөрөнгө эх үүсвэрийн бүтцийг бүрдүүлэх энэхүү загварыг solver программийн тусламжтайгаар тооцоолсон тул байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамаарч өөрчлөгдөх тохиолдолд дахин тооцоолох боломжтой,

бизнесийн байгууллагын удирдлагын нэн чухал арга хэрэгсэл болж ашиглагдана гэж үзлээ.

Дүгнэлт

2015-2017 оны дундажаар тооцоход уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын нийт хөрөнгийн 88,0 хувийг эргэлтийн бус хөрөнгө, санхүүжилтын 89,0 хувийг өр төлбөр эзэлж, тэдгээрийн өсөлт давамгайлсан нийт өрийн харьцаа нэмэгдэх хандлагатай, дотоодын хөрөнгийн зах зээлээс санхүүжилт бүрдүүлэх алхам бараг хийгдэхгүй байна. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хэрээр компаниудын эзэмшигчийн өмчийн дүн нэмэгдэж чадахгүй, өөрийн хөрөнгийн оролцоо 10,0-12,0 хувийг л эзэлж байна. Энэ нь тус салбарын хөрөнгийн ашиглалт, өгөөж сул, үйл ажиллагааны цэвэр ашиг тогтвортой нэмэгдэж чадахгүй байгаатай холбоотой хэдий ч орлогын хуваарилалт, татварын орчин, бодлогын тогтворгүй байдлаас хамаардаг байж болзошгүй. Тус салбарын компаниудын өрийн харьцаа нэмэгдэж, хөрөнгийн ашиглалт өгөөж харьцангуй доогуур байна.

Уул уурхайн салбарын санхүүгийн тайлангийн он дараалсан мэдээллийн сан бүрдүүлж санхүүгийн тогтворгүй байдалд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг дотоодын болон хамтарсан, гадаадын хөрөнгө оруулалттай компаниудаар ангилан судалж дүгнэлт өгөх замаар салбарын бодлогыг тодорхойлох шаардлага тавигдаж байна.

Ашигласан материал

- [1] Сайнжаргал.Б, Наранчимэг.Л “Уул уурхайн компаниудын санхүүгийн төлөв байдлын шинжилгээ, дүгнэлт” сэдэвт ОУЭШХ-ын илтгэл УБ хот 2014 он
- [2] Сайнжаргал. Б “Санхүүгийн тайлангийн шинжилгээ” УБ хот 1999 он
- [3] Наранчимэг.Л, “Санхүүгийн тогвортой байдлын шинжилгээний онол, арга зүйн асуудал” Улаанбаатар хот, Шинро принт ХХК, 2011 он
- [4] Савицкая Г.В. “Методика комплексного анализа хозяйственной деятельности” Изд-во Проспект, Москва, 2015 он
- [5] Эх сурвалж: Кадастрын хэлтэс, АМГТГ (<https://www.mpram.gov.mn/public/pages/131/monthly.report.2018.12.mon.pdf>)
- [6] МХБ, 2017 оны жилийн тайлан, 13-р хуудас
- [7] Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, 2013-2024 он
- [8] Монгол улсын статистикийн эмхэтгэл, Улаанбаатар хот, 2015-2017 он
- [9] Уул уурхайн салбарын статистикийн мэдээ, 2018/IV